

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2023 оны 08 дугаар сарын мэдээ

2023.08.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ **Сумын ИТХ-ын чиглэлээр:** Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр 9 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг “АДПП” төслийн санхүүжилтээр боловсруулан хуулийн дагуу 08 дугаар сарын 24-ны өдөр сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит 8-р хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

б/ **Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:** Тухайн сард дээд газраас 15 албан бичиг ирсний 3 нь хариутай, хугацаа болоогүй-2, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно.

Алтан овооны тэнгэрийг тайх төрийн тахилга 110 жилийн ойн баяр наадмын арга хэмжээнд сумын отог байгуулж ёслол хүндэтгэлийн өндөр хэмжээнд зохион байгуулж ажиллаа.

Засаг даргын тамгын газар, Сумын залуучуудын холбоо хамтран зохион байгуулж буй “Баяндэлгэр цом 2023” спортын бага наадамыг 08 дугаар сарын 11-13 ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.

Хоёр: **Төсөв санхүүгийн чиглэлээр:** Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Статистикийн байгууллагад сарын мэдээг бүрэн дамжуулсан. Орон нутгийн төсвийн байгууллага, Тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг орлоготой уялдуулан олгосон .

Цалин хөлс нэмэгдсэнтэй холбогдох тооцоог хийж төсвийн тодотголоор батлуулж төсвийн сарын хуваарь болон төсвийн баазыг хийж аймгийн төрийн санд хүргүүлж баталгаажуулсан. ЗДТГ, ИТХ,Баг-ийн төсвийн хуваарийг шинэчлэн хийсэн.

2024 оны төсвийн төслийг хийж аймгийн санхүү төрийн сангийн хэлтсийн төсвийн зарлагын мэргэжилтэнтэй хамтран цахим программд шивж хянуулан баталгаажуулсан.

2023 оны хагас жилийн санхүүгийн тайланг байгууллага тус бүр болон нэгтгэсэн тайланг сангийн яамны цахим системд шивж илгээн баталгаажуулсан.

Гурав. **Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** Сумын Цагдаагийн тасаг, хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн нар хилийн 1,2 дугаар заставын ахлагч нар болон ар гэрийхэнд нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт мэдээллийг өгч ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Соёл: Алтан дарь овооны тэнгэрийг тайх төрийн их тахилга 110 жилийн ойн баяр наадмын үеэр хэлхээ тоонотой дарьганга гэр болон ахуйн хэрэглээний 55 үзмэрээр үзэсгэлэн гаргалаа. Үзэсгэлэнд Хонгор багийн Гэндэнжамц гуайн үр ач нарт хадгалагдаж байгаа өвөг дээдсийн хэлхээ тоонотой 6 ханатай гэрт Дарьгангын ард түмний 19-р зууны ахуй амьдралыг харуулсан дэглэлт хийн ихэр хаяа зуух барьж

дарьганга үндэсний хоол хүнсний технологоос хийж сурталчиллаа. / шар тосны хуймаг, сүүний хоол /

“НҮҮДЭЛЧИН-2023” Дэлхийн соёлын фестивальд сумын өвлөн уламжлагч МУСТА, Ард түмний гавъяат дуучин Ж. Өлзийбат 3 дах удаагаа оролцож Дарьганга үндэсний өв соёлоо сурталчиллаа

Эрүүл мэнд: Нийт үзлэгт- 358 урьдчилан сэргийлэх үзлэг – 35, Больницод иргэн хэвтэн эмчлүүлсэн.

АНЭ болон эмч мэргэжилтний холбооноос хамтран хийгдэж буй “Сүрьеэ өвчний үзлэг оношилгоо”-нд 254 иргэн иргэн хамрагдаж зөвлөмж чиглэл өгч ажиллаа.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 6 иргэнийг 6 сарын хугацаатай түр ажлын байраар ханган сумын хэмжээнд ургаж байгаа 20000 гаруй модны арчилгаа усалгааг тогтмол хийж байна.

Цагдаагийн тасаг, Байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хонгор багийн тарвага нутаглаж буй Замын шанд, Нарийны дээд эх, Тарган эх, Баруун, Зүүн салаа зэрэг газруудад хяналт шалгалтыг хийлээ. Өмнөх жилүүдээс өссөн дүнтэй харагдаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: 2021 оны ноосны урамшуулал ороогүй зөрчилтэй 22 малчдын мэдээллийг засаж залруулан аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

Алтан овооны их тахилгын наадмын үеэр хоол үйлдвэрлэл явуулах ААН, иргэдийн мэдээллийг гаргаж аймгийн стандарт хэмжил зүйн хэлтэст хүргүүлэн 2 ААН, 4 иргэн хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан.

2023 оны сумын бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд газрын даамал, бэлчээр хариуцсан мэргэжилтэн, багийн дарга нар ажлын хэсгээрээ 6 багийн 23 цэгт бэлчээрийн даац тодорхойлох хээрийн судалгааны ажил хийж дууссан.